



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/48

Улаангом

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Увс аймгийн Улаангом сумын "Манай баг" гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Х.Дашзэвэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.НАСАНБАТ

“МАНАЙ БАГ” ГЭР ХОРООЛЛЫГ ДЭД БҮТЭЦЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэхээр тодорхойлсон байна.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх зорилтыг тавин аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөхөөр тусгасан.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Аймгийн төвийн авто замын шинэчлэлийг үргэлжлүүлэх, Улаангом сумын зарим ДДТ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, аймгийн төв, гэр хорооллын инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн зураг төслийг хийлгэн, ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, хот суурин газрын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулах зэрэг зорилтуудыг үндэслэн хөтөлбөрийг боловсруулсан.

1.1 Дэд бүтцийн салбарын өнөөгийн байдал

Дулаан хангамж

Улаангом хотын төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээ нь 2 эх үүсвэрээс хангагддаг.

1. Дулаан хангамжийн нэгдүгээр эх үүсвэр нь анх 1986 онд, КЕ-25/14С маркийн 3 зуухтай, 75 тонн уур үйлдвэрлэх хүчин чадалтай баригдаж ашиглалтанд орсон. 2003 онд хувьчлагдаж "Увс дулааны станц" ХХК-д шилжсэн ба 2009 онд уурийн зууханд технологийн шинэчлэл хийж усан халаалтын горимд, 2013 онд өндөр температурын буцламтгай шаталтын горимд шилжүүлсэн. Одоогийн байдлаар суурилагдсан хүчин чадал нь 39Гкал/ц бөгөөд халаалтын системийн дулаан хангамжийн зуухны бодит ачаалал 9,4Гкал/ц байна. Улаангом сумын 362 айл өрх, 165 ААН, 13 төсвийн байгууллагын объектуудыг дулаанаар хангаж байна.

2. Дулаан хангамжийн 2 дахь эх үүсвэр нь 30 Гкал/ц хүчин чадалтай, 7 дулаан дамжуулах төвтэй баригдаж 2014 онд ашиглалтанд орсон. Одоогийн байдлаар

9,9Гкал/ц дулаан үйлдвэрлэн 1412 айл өрх, 35 төсвийн байгууллага, 85 ААН-ийг хангаж байна. Ф219-Ф400мм голчтой 1-р хэлхээний 3.5 км, 2-р хэлхээний 11.27 км шугамтай.

3. Нам даралтын зуухны эх үүсвэрүүд:

Улаангом суманд Солонго талст ХХК-ний 1,2мВт, 6-р сургуулийн 0,4мВт, ССТ-Од ХХК-ний 3,5 мВт, Насан илч ХХК-ний 0,3 мВт, МХС ХХК-ний 1мВт-ын хүчин чадалтай нам даралтын зуухнуудаар ерөнхий боловсролын 3, 5, 6-р сургууль, 8 айлын орон сууц, Битүү зах, Холбооны барилгыг дулааны эрчим хүчээр хангаж байна.

Төвлөрсөн дулаан хангамжийн системд нийтдээ 1774 айл өрх, 250 ААН, 48 төсвийн байгууллагын объектууд холбогдсон байна.

Дулааны станцууд болон нам даралтын зуухны хүчин чадлын ашиглалт:


/2016-2017 оны халаалтын улиралд/

Станцууд	Суурилагдсан хүчин чадал	Зуухны бодит ачаалал
	Гкал/цаг	
Увс Дулааны станц ХХК	39	9,4
Дулааны II станц, ДШС ОНӨААТҮГ	30	9,9
Нам даралтын зуухнууд	5,3	4,5
Нийлбэр	74,3	23,8
Ашиглалтын хувь, %		32,0

Цахилгаан хангамж:

Цахилгаан эрчим хүчний хангамжийн хувьд 1996 оноос ОХУ-ын Чадан мужийн эрчим хүчний системээс 110кВ-ийн 101,3км цахилгаан дамжуулах агаарын шугамаар 110/35/10кВ-ийн хүчдэлтэй 2х16000кВА чадалтай "Улаангом" дэд өртөөний хуваарилах байгууламжаас 1497.4 км шугамаар дамжин хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. 2017 оны байдлаар оргил ачаалал нь 8000 кВа болж байна.

Улаангом сумын сүүлийн 5 жилийн ЦЭХ-ний хэрэглээ /мян.кВт.цаг



Гэр хорооллын айл өрхүүд жилд дунджаар 14140 орчим мянган кВт.цаг эрчим хүч хэрэглэж байгаа бөгөөд сүүлийн 2 жилд бууралттай харагдаж байгаа нь эрчим хүчний хэмнэлт, эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлсөн байх боломжтой.

Өнөөдрийн байдлаар Улаангом сумын хэмжээнд хүчдлийн уналттай, шаардлага хангахгүй цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа нийт 6 (1, 2, 5, 6, 9, 10, 11, 12) багийн 178 өрх байна. Мөн 1, 9-р багт шинээр олгогдсон газрын цахилгаан хангамж шийдэгдээгүй байна.

Цэвэр ус хангамж, Ариутгах татуурга

Аймгийн төвд Цэвэр усны 2 эх үүсвэртэй бөгөөд 1-р эх үүсвэр 4 гүний худаг, 1000 м³ багтаамжтай ус нөөцлөх 1 сан, 5 насостой, 2-р эх үүсвэр 1000м³-ийн ус нөөцлөх 2 сан, гүний 5 худаг, 3 насостай. Дээрхи ус олборлолтын эх үүсвэрүүдийн ус дамжуулах 19,2км шугам хоолойгоор хоногт 1500-1600м³/хон усыг 24 цагийн турш хэрэглэгчдэд тасралтгүй түгээж байна. Төвлөрсөн ус хангамжийн системд 1718 өрх, 197 аж ахуйн нэгж, байгууллага холбогдсон. Суурилагдсан хүчин чадлын 40 хувийг ашиглаж байна. Улаангом сумын 3, 4, 5, 6, 7, 9, 10, 11, 12 дугаар багуудын хүн амыг гидрант 5 усан сан, гүний 5 худгаар дамжуулан баталгаат ундны усаар хангадаг.

Улаангом сумын ариутгах татуургын төвлөрсөн систем 3840м³/хоног хүчин чадалтайгаар баригдан 1986 онд ашиглалтанд орсон, 2001 онд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ус хангамж, ариутгах татуургын нэгдсэн системд шинэчлэлт хийгдэж картын системд шилжсэн ба Улаангом сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглээнээс гарсан бохир усыг 389 худаг 16,6км урт шугам хоолойгоор дамжуулан цуглуулж, татан зайлуулж цэвэршүүлдэг. Ариутгах татуургын шугам сүлжээнд 1587 өрх, 197 аж ахуйн нэгж, байгууллага холбогдсон. Хэдийгээр цэвэрлэх байгууламжийн суурилагдсан хүчин чадал хүрэлцээтэй мэт харагдаж байгаа боловч цэвэршүүлэн байгальд нийлүүлж байгаа бохир усны цэвэршүүлэлтийн хувь стандарт шаардлагыг хангахгүй байгаа учраас цэвэрлэх байгууламжийг зайлшгүй шинэчлэх шаардлага өнөөдөр тулгараад байна.

Авто замын талаар:

Улаангом сум нь 24,2км хатуу хучилттай авто зам, 30,4 км явган хүний зам, 20км зам дагуу гудамжны гэрэлтүүлэгтэй.

Улаангом суманд сүүлийн 4 жилийн байдлаар тээврийн хэрэгслийн тоо 2013 онд 3392, 2014 онд 4004 болж 18 хувиар, 2015 онд 4401 болж 9,9 хувиар тус тус нэмэгдсэн, 2016 онд 4274 болж буурсан байна.



2016 оны байдлаар аймгийн хэмжээнд 8974, Улаангом суманд суудлын 2891, ачааны 716, автобус 174, тусгай 79, мотоцикл 263, чиргүүл 110, механизм 41 тус тус тооллого үзлэгт хамрагдсан байна.



Улаангом сумын дотор Улаангом-Улиасны хэв, Улаангом-Чандмань чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж үзүүлдэг.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон гэр хорооллын өрх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн судалгаа

№	Баг	Нийт өрхийн тоо	Хувийн сууцтай өрхийн тоо	Инженерийн шугам сүлжээнд холбогдсон гэр хорооллын өрхийн тоо			Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ААН-ийн тоо	Инженерийн шугам сүлжээнд холбогдсон ҮҮЭ-ийн тоо			Шаардлага хангаагүй ЦЭХ-ний хангамжтай айл өрхийн тоо	Гэр хорооллын 00 тоо	Гэр хорооллын худгийн тоо
				Дулаан	Цэвэр ус	Бохир		Дулаан	Цэвэр ус	Бохир			
1	1-р баг	535	59	-	-	-	18	-	-	-	58	370	48
2	2-р баг	527	22	-	-	-	3	-	-	-	15	183	3
3	3-р баг	1123	32	24	32	20	130	110	78	63	-	120	37
4	4-р баг	746	311	24	23	-	30	1	2	-	-	600	40
5	5-р баг	689	151	32	26	9	25	4	18	18	18	431	61
6	6-р баг	847	148	-	-	-	27	-	-	-	14	510	46
7	7-р баг	888	232	67	64	7	45	13	20	16	-	580	21
8	8-р баг	197	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	9-р баг	677	75	-	-	-	42	-	-	-	43	420	46
10	10-р баг	992	193	4	5	2	47	7	9	8	3	520	50
11	11-р баг	642	157	13	23	7	23	19	24	20	12	375	18
12	12-р баг	543	70	-	-	-	55	55	25	11	15	402	4
	Нийт	8406	1450	164	173	45	425	209	176	136	178	4511	374
	Гэр хорооллын айл өрхөд эзлэх хувь		17,2	2,5	2,6	0,68		49,1	41,4	32	2,1		

Улаангом сум нь 12 багийн 8406 өрх, 30688 хүн амтай, үүнээс 6623 өрх нь гэр хороололд амьдарч байгаа нь нийт өрхийн 78,8 хувийг эзэлж байна.

Гэр хорооллын айл өрхүүдийн 17,2 хувь болох 1450 айл хувийн байшинд амьдардаг бөгөөд эдгээр айлуудын 11,3% дулааны, 11,9% цэвэр усны, 3,1% нь бохирын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байна.

2016 оны эцсийн байдлаар 6758 агаарын бохирдуулагч эх үүсвэр тоологдсон бөгөөд халаалтын улиралд гэрийн зуух, нам даралтын усан халаалтын зууханд ойролцоогоор жилд 28,8 мян.тн нүүрс, 13,8 мян.м3 мод, 1,9 мян.тн бусад төрлийн түлш түлэн, 4164 тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцон агаар, орчныг бохирдуулж байна.

Өвлийн улиралд хийгдсэн Улаангом сумын агаарын чанарын хяналтаар агаарын агууламжийг агаарын чанарын стандартын хүлцэх хэм хэмжээтэй харьцуулахад агаар дахь хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2) болон угаарын хий, том ширхэгтэй тоосны агууламж 1-2 дахин их гарсан байна.

Мөн сумын төвийн гэр хорооллын айл өрхийн 292, ААН-ийн 82 худгаас өнөөдрийн байдлаар 205 худгийн усыг ундны усны зориулалтаар ашиглаж байна. Өнөөдөр гэр хороололд эрүүл ахуйн шаардлага хангахгүй 4511 энгийн нүхэн жорлон, муу усны нүх байна.

Гэр хороололд эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн шаардлага хангахгүй, нүхэн жорлон, муу усны нүхтэй зэрэгцэн, хөрс, хөрсний усаар дамжин бохирдох аюултай худгийн усыг ундны усан хангамжид ашиглаж байгаа нь ундны усны чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байна.

Иймд хөрс, агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн амьдрах аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх, хот төлөвлөлтийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, газрын үнэ цэнийг нэмэгдүүлэх үүднээс гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэхэд суурилагдсан Дулааны 2 эх үүсвэртэй, хүчин чадлын нөөц хүрэлцээтэй цэвэр усан хангамжийн 2 үүсвэртэй зэрэг давуу талууд байгаа ч гэр хорооллын газар олголт замбараагүй хийгдсэнээс шугам сүлжээ /дулаан, цэвэр, хэрэглээний халуун ус, бохир, холбоо/ татахад хүндрэлтэй, зарим дулаан дамжуулах төвийн хүчин чадал бага, дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугам сүлжээний зарим хэсэг нь хуучирч муудсан, гэр хорооллын амины орон сууцнуудын барилгууд дулаан алдагдал ихтэй, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх шаардлагатай, гэр хорооллын хатуу хучилттай авто замын сүлжээ харьцангуй сул, гадаргын ус зайлуулах системгүй, инженерийн шугам сүлжээ, авто замын барилга угсралтын ажлын өртөг өндөр зэрэг тулгамдсан асуудлууд байна.

Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэн, авто замын сүлжээг өргөтгөснөөр гэр хорооллын амины орон сууцтай айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдсон тохилог хувийн орон сууцанд амьдрах, үл хөдлөх хөрөнгөтэй болох, шинээр амины орон сууц, нийтийн орон сууц барих, авто замаар ая тухтай, аюулгүй зорчих, нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх боломж бүрдэх юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбож, авто замын сүлжээ бий болгох замаар хүн амын эрүүл аюулгүй, ая тухтай амьдрах орчныг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх таатай нөхцөлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалахад оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн багуудад инженерийн шугам сүлжээ, авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Зорилтууд

4.1 Улаангом сумын төвийн 4, 5, 7, 11-р баг, 2,6-р багийн зарим хэсгийн дулаан, цэвэр, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээний хүчин чадал, хангамжийг нэмэгдүүлэх, өргөтгөх, шинэчлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 4.1.1 Инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулах.
- 4.1.2 Инженерийн шугам сүлжээ барихад зориулан газрын асуудлыг шийдвэрлэх.
- 4.1.3 Дулаан дамжуулах төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.
- 4.1.4 Дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх.
- 4.1.5 Хуучин болон иргэд өөрийн хөрөнгөөр барьсан дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээг шинэчлэн сайжруулах.

4.2 Улаангом сумын төвийн багуудийн цахилгаан дамжуулах шугам сүлжээний хүчин чадал, хангамжийг нэмэгдүүлэх, өргөтгөх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 4.2.1 Инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулах.
- 4.2.2 Инженерийн шугам сүлжээ барихад зориулан газрын асуудлыг шийдвэрлэх.
- 4.2.3 Шинэ суурьшлын бүс болон хүчдлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах.

4.3 Гэр хорооллын хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 4.3.1 Авто замын өргөтгөл, гадаргын усны сувагчлалтын ажлын зураг төсөл боловсруулах.

- 4.3.2 Замын трассын дагуу инженер геологийн хайгуул судалгаа хийх.
- 4.3.3 Гэр хорооллын дундах төлөвлөгдсөн авто замыг хатуу хучилттай болгох
- 4.3.4 Гадаргын ус зайлуулах сувагчлал татах
- 4.3.5 Авто замын дагууд автобусны буудал барих

4.4 Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

- 4.4.1 Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон болон холбогдох боломжтой барилгын дулаан алдагдлыг бууруулах.
- 4.4.2 Шинээр барих хувийн сууцыг нэг маягийн зургаар барих.
- 4.4.3 Инженерийн шугам сүлжээнд холбогдохдоо мэргэжлийн байгууллагаас гаргасан техникийн нөхцлийн дагуу ажлыг гүйцэтгэх.
- 4.4.4 Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжиж ажиллах.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

1-р үе шат: 2017-2019 он

Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төслийг боловсруулан, барилга угсралтын ажлыг эхлүүлэх.

2-р үе шат: 2020-2021

Инженерийн шугам сүлжээ, авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг дуусган иргэдийн ая тухтай, аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх.

ЗУРГАА: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

6.1 Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2017 оны 9 сар	Хүрэх түвшин 2021 он
		1	Инженерийн хангамжтай амины сууцанд амьдарч буй гэр хорооллын өрхийн тоо
2	Стандарт шаардлагад нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа өрхийн эзлэх хувь	97,9	100
3	Хатуу хучилттай авто замын хэмжээ; км	24,2	37,0

6.2 Хүрэх үр дүн

№	Зорилтууд	1-р үе шат	2-р үе шат
1	Улаангом сумын төвийн багуудийн инженерийн шугам сүлжээний хүчин чадал, хангамжийг нэмэгдүүлэх, өргөтгөх, шинэчлэх	Инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулан, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн БУА-ыг эхлүүлэх нөхцөл бүрдсэн байна.	Дулаан дамжуулах төвийн хүчин чадал нэмэгдэж, дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийгдэж гэр хорооллын сууцтай айл өрхүүд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох, шинээр төвлөрсөн орон сууц барих нөхцөл бүрдэж байна.
		Инженерийн шугам сүлжээ барихад зориулан газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.	Шинэ суурьшлын бүс болон хүчдлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамж сайжирч айл өрхүүд 100% шаардлага хангасан эрчим хүчээр хангагдсан байна.
		Инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн байна.	
2	Гэр хорооллын хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх	Авто замын өргөтгөл, гадаргын усны сувагчлалын ажлын зураг төсөл боловсруулан, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэн, авто замын өргөтгөлийн ажил эхэлсэн байна.	Хотын авто замын сүлжээг 12,8км-ээр нэмэгдүүлэн авто замын нэвтрэх чадварыг сайжруулан, ногоон байгууламж, гэрэлтүүлгийг бий болгон, нийтийн тээврийн үйлчилгээ өргөжин, аюулгүй орчныг бүрдүүлсэн байна.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

1. Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Улаангом сумын ЗДТГ хариуцан зохион байгуулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дээд төвшиндөө Сангийн яамны “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгж, БХБЯ, ЭХЯ, ЗТХЯам болон төслийн байгууллагуудтай хамтран ажиллана.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад Увс Дулааны станц ХХК, Дулааны II станц, ДШС ОНӨААТҮГ, Чандмань Увс ХХК, ЦТС ХХК хамтран ажиллана.
3. Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ нь 2 жилд нэг удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг ИТХ-д тайлагнана.


ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл
- Гадаадын орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж
- Бусад эх үүсвэр

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2018 оны 04 сарын 18-ны өдрийн 4/14 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
/2018-2021 он/



№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шаардагдах хөрөнгө, сая.төг	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага
Нэг. Дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээний чиглэлээр:							
1	1.1 Ажлын зураг төслийг боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулах.	1.1.1 Инженерийн шугам сүлжээний трасс тогтоох, техникийн нөхцөл авч, зургийн даалгавар боловсруулах	2018	5,0	Техникийн нөхцөл, зургийн даалгаварт ажлын тоо хэмжээ, хүчин чадлыг бүрэн тусгасан байна.	Дулаан, цэвэр, хэрэглээний халуун ус, бохир, шилэн кабелийн шугам сүлжээний трасс тогтоон, зургийн даалгавар боловсруулсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ, ЦТС ХХК, Чандмань Увс ХХК, Дулааны станцууд
		1.1.2 Улаангом сумын хэмжээнд мэргэжлийн байгууллагаар ажлын зураг төсөв боловсруулгах	2018-2019	1278,9	Зураг төслийн ТЗ эзэмшигчээр ажлыг гүйцэтгүүлсэн байна.	ИШС-ний зураг төсөл боловсруулагдсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ
		Дүн		1283,9			
2	1.2 Инженерийн шугам сүлжээ барих зураг төсөл боловсруулах	1.2.1 Инженерийн шугам сүлжээний трассын дагууд газар чөлөөлөлт хийх шаардлагатай хэсгийн судалгаа гаргах	2018		Трассын дагуу мэргэжлийн байгууллагууд чөлөөлөх газрын хэмжээг тогтоосон байна.	Трассын дагуу газар олголт шаардлагатай хэсгийн судалгаа хийгдсэн байна.	ГХБХБГ, сумын ЗДТГ
		1.2.2 Нөхөн олговрын хэмжээг тогтоох	2018		Нөхөн олговор олгох ААН, айл өрхийн тоог тогтоосон байна.	Нөхөн олговрын хэмжээг тогтоосон байна.	ГХБХБГ, сумын ЗДТГ
		1.2.3 Газар чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх	2018-2019		Судалгааны дагуу тогтоогдсон хэсгийн газар чөлөөлөлт хийгдсэн байна.	Шинээр байгуулагдах инженерийн шугам сүлжээний дагуу газар чөлөөлөлт хийгдсэн байна.	АЗДТГ, ГХБХБГ сумын ЗДТГ
		1.3.1 Дулаан дамжуулах төв 1-ийн хүчин чадлыг	2019-2020	280.0	Тоноглолын хүчин чадал нэмэгдсэн байна.	ДДТ-ийн хүчин чадал нэмэгдэж хэрэглэгч нэмж холбох нөхцөл	ХХДБ төсөл, АЗДТГ, ОНӨГ,

3	1.3 Дулаан төвийн чадал дамжуулах хүчин нэмэгдүүлэх	нэмэгдүүлэх				бүрдсэн байна.	Дулааны II станц
		1.3.2 Дулаан дамжуулах төв 3-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	2019-2020	268,0	Тоноглолын хүчин чадал нэмэгдсэн байна.	ДДТ-ийн хүчин чадал нэмэгдэж хэрэглэгч нэмж холбох нөхцөл бүрдсэн байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ОНӨГ, Дулааны II станц
		1.3.3 2, 5 6-р багт ДДТөв шинээр байгуулах	2019-2020	2960,0	Салаа шугам татах нөхцөл бүрдсэн байна.	төв шугам, ДДТ барьсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ОНӨГ, Дулааны II станц
		Дүн		3508,0			
4	1.4 Дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх	1.4.1 Улаангомьын 2, 4, 5, 6, 7, 11-р багт гадна дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун усны шугам татах, 12,4км	2019-2020	8177,4	Хэрэглэгчид холбогдох нөхцөл бүрдсэн байна.	Гадна инженерийн шугам сүлжээ баригдсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		1.4.2 ДДТ5-аас хэрэглэгч хүртэлх гадна дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун усны шугам татах,	2018-2019	921,5	Хэрэглэгчид холбогдох нөхцөл бүрдсэн байна.	Гадна инженерийн шугам сүлжээ баригдсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		1.4.3 2, 4, 6, 7-р багт бохирын өргөх станц барих	2019-2021	2717,2	Хэрэглэгчид холбогдох нөхцөл бүрдсэн байна.	КНС баригдсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		1.4.4 2, 4, 5, 6, 7, 11-р бохир усны шугам татах, 14,3км	2019-2021	3101,7	Хэрэглэгчид холбогдох нөхцөл бүрдсэн байна.	Гадна инженерийн шугам сүлжээ баригдсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		1.4.5 Улаангом суманд "Ухаалаг худаг" байгуулах	2019	60,0	Хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээ сайжирсан байна.	5 худгийг "Ухаалаг худаг"-т шилжүүлсэн байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ, Чандмань Увс ХХК
		Дүн		14977,8			
5	1.5 Ашиглалтын шаардлага	1.5.1 ДДТ1-ээс Хүнсний үйлдвэр, 6	2020-2021	2374,7	Шинэчлэгдсэн шугам сүлжээнд	Шугам сүлжээ шинэчлэгдсэн байна.	ХХДБ төсөл, АЗДТГ,

	хангахгүй дулаан, цэвэр ус, хэрэглээний халуун ус, бохирын шугам сүлжээг шинэчлэн сайжруулах	айлын чиглэлийн шугам сүлжээг шинэчлэх, 453м			холбогдсон хэрэглэгчид хэрэглээний халуун усаар хангагдах нөхцөл бүрдэнэ.		ГХБХБГ, Сумын ЗДТГ
		Дүн		2374,7			
Хоёр. Цахилгаан хангамжийн чиглэлээр:							
6	2.1 Шинэ суурьшлын бүс болон хүчдлийн уналттай багуудад ЦДАШ, дэд өртөөний өргөтгөл, шинэчлэл хийх	2.1.1 Улаангом сумын 1-р багийн хүчдлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2018	263,3	260 гаруй айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1.2.Улаангом сумын 1-р багийн нутаг дэвсгэр Цагаан бураа орчмын цахилгаан хангамж	2021	177,9	22 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1.3 Улаангом сумын 2-р багийн хүчдлийн уналттай айл өрхийн цахилгаан хангамж	2019	20,3	15 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1.4 Улаангом сумын 5-р багийн хүчдлийн уналттай хороолол болон Гашууны голын чиглэлийн цахилгаан хангамж	2020	172,9	73 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1.5 Улаангом сумын 6-р багийн хүчдлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2020	53,8	14 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1 6 Улаангом сумын 9-р багийн хүчдлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2019	185,6	43 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		2.1.7 Улаангом сумын 11-р багийн хүчдлийн уналттай бүсийн	2020	11,7	12 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ

		цахилгаан хангамж 2.1.8 Улаангом сумын 12-р багийн хүчдлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2019	287,6	15 айл өрхийн цахилгаан хангамж сайжирсан байна.	Хэрэглэгчдийн цахилгаан хангамж сайжирсан байна.	АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		Дүн		1173,1			
Гурав. Авто замын чиглэлээр							
7	Авто замын ергөтгөл, гадаргын усны сувагчлалтын ажлын зураг төсөл боловсруулах.	Төлөвлөгдсөн авто замын зураг төсөл боловсруулах	2018	548,8	Техникийн нөхцөл, зургийн даалгаварт ажлын тоо хэмжээ, хүчин чадлыг бүрэн тусгасан байна.	Авто замын зам, сувагчлалын трасс тогтоон, зургийн даалгаврын дагуу зураг төсөл боловсруулсан байна.	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
8	Гэр хорооллын дундах төлөвлөгдсөн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх	Цагаан хөшөө автобусны 1-р буудал - Автобусны 2-р буудал чиглэлийн	2019-2020	1601,2	Шинээр баригдах авто замын урт, км	1,79	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
		Заяцкийн урдуур цас тогтох дэлгүүр хүртэл- 0,98 км	2019-2020	641,2	Шинээр баригдах авто замын урт, км	0,98	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Увс Эрдэм ахлах сургуулийн доод талаас – Шунхлай ШТС уулзвар хүртэл	2019-2020	1949,1	Шинээр баригдах авто замын урт, км	2,72	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		12-р багийн хороолол дундах авто зам	2020-2021	1100,0	Шинээр баригдах авто замын урт, км	1,0	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Хаш барилгын материалын дэлгүүрийн урд талаар Мон тува ХХК байр хүртэл, зогсоолын хамт	2020-2021	275,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,25	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Мон Тува ХХК байрны урд талаас Заяцкийн урдах зам хүртэл	2020-2021	627,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,57	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, ЗДТГ

		12-р баг туслах зам	2019-2020	418,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,38	АЗДТГ, ГХБХБГ, ЗДТГ
		9,12-р баг Буянт хороолол, Гашуун хороолол	2019-2020	3938,0	Шинээр баригдах авто замын урт, км	3,58	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, Улаангом сумын ЗДТГ
		Банкны 24 айлын баруун талын зам	2020-2021	154,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,14	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, ЗДТГ
		8-р цэцэрлэгийн дээд талаар модтой гудамж хороолол руу	2020-2021	594,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,54	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		8-р цэцэрлэгийн урд уулзвараас хойш чиглэлд 250 м	2020-2021	374,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,34	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Цаст дэглий дэлгүүрийн замын урд уулзвараас хойш чиглэлд	2020-2021	253,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,23	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Заан дэлгүүрийн урд уулзвараас хойш чиглэлд	2020-2021	396,0	Шинээр баригдах авто замын урт, км	0,36	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Дүн		12869,3		12,88км	
9	Гадаргын зайлуулах сувагчлал татах ус	Арын 4 замаас – Улиасны хэв чиглэл	2019-2021	446,2	Шинээр татах сувагчлалын урт, км	4,28	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		8-р цэцэрлэгийн урд талын авто замаас	2019-2021	16,7	Шинээр татах сувагчлалын урт, км	0,16	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Ачит нуур төв–Гранд зочид буудал-ТНХ уулзвар-Увс-Эрдэм	2018-2020	422,2	Шинээр татах сувагчлалын урт, км	4,05	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ,

		ахлах сургуулийн урд чиглэл					сумын ЗДТГ
		ТНХ ХХК-ны урд уулзвар - Цастогтох дэлгүүр чиглэл	2020-2021	25,0	Шинээр татах сувагчлалын урт, км	0,24	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		ОБГ-ын урд уулзвар – Цастогтох дэлгүүр – Улиасны хэвийн урд чиглэл	2020-2021	323,2	Шинээр татах сувагчлалын урт, км	3,1	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Цагаан хаалга-ШШГГ-Увс-АЗЗА ТӨХК-ны байр чиглэл	2020-2021	166,8	Шинээр татах сувагчлалын урт, км	1,6	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Дүн		1400,1		13,4км	
10	Автобусны буудал барих	Шинээр барих буудлууд	2018-2020	60,0	Шинээр баригдсан буудлын тоо	6	ХХДБ төсөл, АЗДТГ, ГХБХБГ, сумын ЗДТГ
		Дүн		60,0			
	Нийт дүн			37646,9			